



Global Network of Sex Work Projects
Promoting Health and Human Rights

БИЕЭ ҮНЭЛЭЛТИЙН ТӨСЛИЙН ДЭЛХИЙН СҮЛЖЭЭ

Эрүүл мэнд, хүний эрхийг дэмжих нь

NSWP нь дэлхий даяар биеэ үнэлэгчдийн дуу хоолойг дэмжиж, эмэгтэй, эрэгтэй болон трансжендэр биеэ үнэлэгчдийн эрхийг хангах бүс нутгийн сүлжээг холбож ажилладаг байна. Тус байгууллага нь хүний эрхэд суурилан эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, бэлгийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх болон биеэ үнэлэгчдийг өөрсдийгөө тодорхойлж, хүндэлж харьцах тал дээр нийгэмд нөлөөлөх байдлаар дэмжин ажилладаг.

БИЕЭ ҮНЭЛЭЛТ БОЛ АЖИЛ ЮМ:

Зөвхөн Хүний Эрхийг Хамгаална

Энэхүү гарын авлагыг Роберт Карр иргэний нийгмийн сүлжээний сангаар дамжуулан Глобал сан санхүүжүүлсэн болно.

NSWP нь тус гарын авлага нь түлхүүр олон нийтэд эрүүл мэнд болон хүний эрхтэй холбоотой тэдэнд үүсэж буй заагыг холбох нэг хэсэг юм. Энэхүү өвөрмөц хөтөлбөр нь нийтлэг сорилтуудтай тулгардаг биеэ үнэлэгчид, мансууруулах бодис хэрэглэгчид, бэлгийн цөөнх хүмүүсийн хүний эрхийн зөрчлийг тодорхойлж, тэдгээрт ХДХВ болон бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгохыг зорьсон.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.hivgaps.org хаягаар орж үзнэ үү

1. **БҮЗХА**- Бие үнэлэгчдэд зориулсан хэрэгжүүлэх аргачлал
2. **БҮХТДС**- Бие үнэлэлттэй холбоотой төслийн дэлхийн сүлжээ
3. **ХДХВ**- Хүний дархлал хомсдлын вирус
4. **БЗДХ**- Бэлгийн замаар дамжих халдвар
5. **ДОХ**- Дархлал хомсдлын вирус
6. **РВЭЭ**- Ретровирусын эсрэг эмчилгээ
7. **ТББ**- Төрийн бус байгууллага
8. **ДЭМБ**- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
9. **НҮБ**- Нэгдсэн үндсэстний байгууллага
10. **НҮБХАС**- Нэгдсэн үндсэстний байгууллагын хүн амын сан

АГУУЛГА

Танилцуулга	2
SWIT гэж юу вэ?.....	2
Ухаалаг гарын авлага гэж юу вэ?	2
Бүтэц	3
Зөвлөмжүүд 2012.....	4
Биеэ үнэлэгчдэд ХДХВ, БЗДХ-ын цогц хөтөлбөр хэрэгжүүлэх зарчмууд.....	5
Биеэ үнэлэгчдийг чадавхжуулах	6
Биеэ үнэлэгчдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх	9
Олон нийтийн манлайлал бүхий үйлчилгээ.....	11
Биеэ үнэлэгчдийн удирдлагыг нийгэмд хүргэх	11
Түр хамгаалах байр	12
Биеэ үнэлэгчдийн хороо болон зөвлөх бүлгүүд	14
Бэлгэвч болон чийгшүүлэгчийн тухай хөтөлбөр	15
Эмнэлгийн тусламж болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	17
Сайн дурын ХДХВ-ийн зөвлөгөө, шинжилгээ	18
Ретровирусын эсрэг эмчилгээ.....	19
Сүрьеэ	19
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгч биеэ үнэлэгчдэд зориулсан нэмэлт үйлчилгээ	19
БЗДХ-ын үйлчилгээ	19
Биеэ үнэлэгчдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээг шийдвэрлэх .	20
Сэтгэцийн эрүүл мэнд	20
Хөтөлбөрийн удирдлага	21

ТАНИЛЦУУЛГА

ХДХВ-ийн халдвар авах хамгийн өндөр эрсдэлтэй бүлэг хүмүүс бол Биеэ үнэлэгчид юм. Үүнд олон шалтгаан байгаа боловч үүгээр хязгаарлагдахгүйгээр ажлын байрны аюултай нөхцөл байдал, бэлгэвчийн тогтмол бүс хэрэглээ, хүртээмж муутай эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг хамаарна.

Биеэ үнэлэгч гэдэгт мөнгө болон бусад хэрэгцээт зүйлийг бэлгийн хавьталд орж солилцоонд нь хүлээн авч буй насанд хүрсэн болон залуу (18-аас дээш насныхан) эмэгтэй, эрэгтэй, трансжендэр хүмүүс хамаарна.

SWIT (БХЭХХ) гэж юу вэ?

Биеэ үнэлэгчдэд зориулсан ХДХВ болон БЗДХ-ын цогц хөтөлбөр хэрэгжүүлэгч:

Хамтын ажиллагааны практик арга барилууд буюу Бие үнэлэгчдэд зориулан хэрэгжүүлэх аргачлал (SWIT) нь ХДХВ, БЗДХ-ын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх стратегиудыг хэрэгжүүлэх, биеэ үнэлэгчдийг чадавхижуулахад чиглэсэн зөвлөмж


өгөх томоохон баримт бичиг юм. Тус баримт бичгийг 2013 онд ДЭМБ, НҮБХАС, НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр, Биеэ үнэлэлтийн төслүүдийн дэлхийн сүлжээ (NSWP), Дэлхийн Банк зэрэг хамтран анхлан санаачилсан юм.

SWIT-ийн зөвлөмжүүд нь ДЭМБ-ын Нийгмийн эрүүл мэндийн талаарх зөвлөмж болох ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эмчлэх болон бага, дунд орлоготой орнуудын биеэ үнэлэгчдэд бэлгийн замаар дамжих бусад халдваруудаас сэргийлэх удирдамжаас санаа авсан. Энэхүү нийгмийн эрүүл мэндийн талаарх зөвлөмж нь NSWP-ийн тайлбар, үнэ цэнийн судалгаагаар баталгаажсан юм.

Тус зөвлөмжүүд нь ХДХВ, ДОХ, БЗДХ-ын хөтөлбөрийн удирдлагууд, ТББ-ууд, үүн дотор бие үнэлэгчид, эрүүл мэндийн ажилтнуудаар удирдуулсан байгууллагуудад зориулагдсан болно.

Ухаалаг хөтөч гэж юу вэ?

Энэхүү ухаалаг хөтөч нь та бүхэнд SWIT-ийн гол хэсгүүдийн товч дүгнэлтийг англи хэл дээр өгөх болно. Та бүхэн энэхүү хөтөчөөр дамжуулан хүний эрхэд тулгуурласан үйлчилгээ үзүүлэхдээ ашиглах боломжтой бөгөөд эдгээр сэдвүүдийн хүрээн дэх ямар ч төрлийн дэлгэрэнгүй мэдээллийг авахаар хандах боломжтой. БҮЗХА буюу SWIT программыг та бүхэн PDF хэлбэрээр Англи, Франц, Спани, Орос болон Монгол хэлээр татаж авах боломжтой.



СТРАТЕГИ (Арга барил)

2012 оны зөвлөмжүүдийн нэг болон хэд хэдийг дагаж мөрдөхөд зориулж SWIT програм нь дараах өргөн хүрээний 6 сэдвийг хамааруулж байна. Үүнд:

1. Олон нийтийг чадавхжуулах
2. Биеэ үнэлэгчдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх
3. Олон нийтийн манлайлал бүхий үйлчилгээ
4. Бэлгэвч болон чийгшүүлэгчийн тухай хөтөлбөр
5. Эмнэлэгийн тусламж болон дэмжлэг үзүүл үйлчилгээ
6. Хөтөлбөрийн удирдлага болон байгуулагуудын чадавхийг бэхжүүлэх

Зурагт сэдвүүд хэрхэн хоорондоо холбогдож байгааг харуулж байна. Олон нийтийг чадавхжуулж, тэдний эрх мэдлийг нэмэгдүүлэх нь SWIT-ийн бүх зөвлөмжүүдийн гол цөм нь юм.



2012 ОНЫ ЗӨВЛӨМЖҮҮД

2012 оны Зөвлөмжүүд сайн туршлага болон нотолгоонд тулгуурласан гэх дараах хоёр төрөлтэй.

Сайн туршлагын зөвлөмжүүд нь нийтлэг ойлголт, ёс суртахуун болон хүний эрхэд суурилсан өргөн хүрээний зарчмуудын цогц юм. Эдгээр нь шинжлэх ухааны нотолгоонд тулгуурладаггүй харин биеэ үнэлэгчдийн туршлагаар урган гарч ирдэг.

Нотолгоонд суурилсан зөвлөмжүүд нь шинжлэх ухааны туршлагад тулгуурласан байдаг учир арга зүйн ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл энэ нь бие үнэлэгчдийн туршлагад тулгуурлан батлагдсан юм.

Сайн туршлагын зөвлөмжүүд:

1. Бүх улсууд биеэ үнэлэлтийн ялгаварлан гадуурхалтын эсрэг чиглэн ажиллах. Түүнчлэн эрүүгийн бус хуулиудыг шударга бусаар хэрэглэх явдал, биеэ үнэлэгчдийн эсрэг чиглэсэн зохицуулалтуудыг арилгах.
2. Төр биеэ үнэлэгчдэд тохиолдох боломжтой ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл болон бусад эрхийн зөрчлийн эсрэг хүний эрхийн баталгааг хангаж ХДХВ болон БЗДХ-ын нөлөөг багасгахын тулд тэдний эрхийг дээдэлсэн хууль батлах. Тэдгээр хуулиуд нь биеэ үнэлэгчдийн нийгэм, эрүүл мэнд, санхүүгийн үйлчилгээ авах эрхийг баталгаажуулахад чиглэх.
3. Гутаан ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолтоос ангид байх зарчим болон эрүүл мэндээ хамгаалах зарчмын дагуу эрүүл мэндийн үйлчилгээ нь боломжит, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байх
4. Биеэ үнэлэгчдийн хүчирхийлэл ХДХВ-ийн эрсдэлийн эх үүсвэр бөгөөд энэхүү эрсдэлээс биеэ үнэлэгчдийн удирдлага бүхий байгууллагууд болон биеэ үнэлэгчидтэй хамтран ажиллах замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Нотолгоонд суурилсан зөвлөмжүүд:

1. Биеэ үнэлэгчдийн бүлгийг хүчирхэгжүүлэх, тэднийг чадавхжуулахад чиглэсэн арга хэмжээний багц бодлогыг санал болгох
2. Биеэ үнэлэгчид болон тэдний үйлчлүүлэгчдийн дунд бэлгэвчийн хэрэглээний тогтмол, зөв хэрэглээг дэмжих, сурталчлах
3. БЗДХ-тэй эсэх нь мэдэгдээгүй байгаа бие үнэлэгчдэд үзлэн санал болгох.
4. БЗДХ-ийн халдвар өндөр тархалттай, эмнэлгийн үйлчилгээ хязгаарлагдмал байгаа тохиолдолд шинж тэмдэг илэрдэггүй БЗДХ-ийн урьдчилан хийгдэх тогтмол эмчилгээг эмэгтэй биеэ үнэлэгчдэд санал болгох
5. Биеэ үнэлэгчдэд ХДХВ-ийн сайн дурын зөвлөгөө, шинжилгээ санал болгох
6. ХДХВ-ийн халдвартай олон нийтэд одоогийн ДЭМБ-ийн ретровирусын эсрэг эмчилгээний зөвлөмжийг хүргэх
7. Мансууруулах бодис тарьж хэрэглэгч биеэ үнэлэгчдэд тохиох хор хөнөөлийг бууруулах ДЭМБ-ийн зөвлөмжийг хэрэглэх (опиоид орлуулах эмчилгээ, зүү, тариурын хөтөлбөрүүд)
8. Нярайн үедээ вакцинжуулалтанд хамраагдаагүй бие үнэлэгчдийг гепатит В вирусын дархлаажуулалтанд хамруулах

Биеэ үнэлэгчдэд ХДХВ, БЗДХ-ын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчмууд

Эдгээр зарчмууд нь 2012 оны Зөвлөмжүүд болон БХЭХХ-ийн зөвлөмжүүдэд тулгуурласан болно.

1. Олон нийтийг чадавхжуулах
2. Хөтөлбөрийн загвар, хэрэгжилт, хяналт үнэлгээ дэх биеэ үнэлэгчдийн оролцоо, манлайлал
3. Бүтцийн бэрхшээлийг шийдвэрлэх
4. Шат дараалалтайгаар үндэсний бодлогын түвшин хүртэл ажиллах
5. Хөтөлбөр нь биеэ үнэлэгчдийн бүлэгт (цаашид бүлэг гэх) хэрэгцээтэй бүх үйлчилгээг багтаасан, тэдгээрийг нэгтгэх зохицуулах илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга зам байх
6. Тухайн улс ядуу буухай, өндөр хөгжилтэй эсэхээс үл харгалзан эдгээр зөвлөмж, зарчмууд тэгш үйлчилнэ

ОЛОН НИЙТИЙГ ЧАДАВХЖУУЛАХ

Бүлгийг чадавхжуулах нь биеэ үнэлэгчид хөтөлбөрийн хүрээнд хувиараа эсхүл хамтаар эзэмших процесс юм. Үнэ цэнэ, давуу талын судалгаанд эрүүл мэнд, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд тус бүлгийг өөрсдийг нь чадавхжуулах нь зайлшгүй шаардлагатай гэдгийг биеэ үнэлэгчид өөрсдөө хүлээн зөвшөөрсөн билээ.

Биеэ үнэлэгчдийг чадавхжуулах гэдгийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- Бие үнэлэгчид туслалцаа үйлчилгээнд бүгд хамрагдах
- Оролцогчдын оролцоход тулгарах саадыг арилгах
- Биеэ үнэлэгчдийн холбоо, удирдлага, иргэний нийгэм болон дотоодын бүх холбоотнуудын түншлэлийн хүчирхэгжүүлэх
- Хамтын ажиллагааг дэмжих орчныг бүрдүүлэх
- Үйл ажиллагааг тэргүүлэх: зөвхөн биеэ үнэлэгчид өөрсдөө л өөрсдийн хэрэгцээ, шаардлагыг хамгийн сайн мэдэх бөгөөд зохих утгаар нь шийдвэрлэх арга замыг хамгийн сайн тодорхойлно
- Хөтөлбөрийн загвар, хэрэгжилт, удирдлага, үнэлгээний асуудалд биеэ үнэлэгчдийн оролцоог хангах
- Биеэ үнэлэгчдийн байгууллагууд, бүлгийг санхүү болон бусад эх үүсвэрээр хангах

Олон нийтийг чадавхжуулах 8 чухал элемент:

1. Биеэ үнэлэгч олон нийттэй хамтран ажиллах
2. Биеэ үнэлэгчийн удирдлагын хүртээмжийг өргөжүүлэх
3. Биеэ үнэлэгчдийн нэгдмэл байдлыг хөгжүүлэх
4. Дотоодын хэрэгцээ, нөхцөл байдалд тохируулах
5. Хүний эрхийн цар хүрээг өргөжүүлэх
6. Хамтын ажиллагааг хөгжүүлэх
7. Бодлого тодорхойлох, боломж бүхий орчинг бүтээх
8. Тогтвортой байдлыг хадгалах



Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч ихэнх үйлчилгээ үзүүлэгчид бие үнэлэгчдийг хөтөлбөр хэрэгжүүлэх үйл явцал хамруулдаггүй ч бие үнэлэгчдийг тул үйл хэргийг хөгжүүлэх, ажиллах үйл ажиллагаанд татан оролцуулах нь нэн чухал.

Бие үнэлэгчдийн үр нөлөөтэй оролцоо гэдэгт:

- Өөрсдийг нь хэн, хэрхэн төлөөлөхийг сонгох
- Үйл ажиллагаанд хэрхэн хувь нэмрээ оруулж оролцохоо сонгох
- Оролцох эсэхээ сонгох мөн
- Хамтын ажиллагааны хүрээнд бие үнэлэгчид бусадтайгаа ижил дуу хоолой (санал)-тойгоор оролцохыг ойлгоно.

Бие үнэлэгчдэд үйлчилгээ үзүүлэгчдийг бие үнэлэгчидтэй ажиллаж, тэднийг чадвахжуулах, эрх мэдлийн нь нэмэгдүүлэх чухал элементүүдийг танилцуулсан байх шаардлагатай. Мөн бие үнэлэгчидэд хийгдсэн ажлуудаас илүүтэй цаашдын урт хугацааны зорилтуудыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах нь чухал юм.

Бие үнэлэгчдийг чадавхжуулах үйл ажиллагааг идэвхтэй байлгах, бэхжүүлэх зарим стратегиуд:

1. Бие үнэлэгчдийн нэгдмэл байдлыг хөгжүүлэх
2. Дотоодын хэрэгцээ, нөхцөл байдалд тохируулах: хэдийн бие үнэлэгчдийн хэрэгцээ цагийн эрхээр өөрчлөгдөх ч гэсэн тэдний хэрэгцээнд тулгуурлан ажиллах нь хамгийн гол зорилго юм. Тийм учраас уян хатан байдал ач холбогдолтой байна
3. Хүний эрхийг дэмжих, сурталчлах: төрийн зүгээс бэлгийн хөдөлмөр эрхлэгчдийн эрхийг хүндэтгэсэн, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс хамгаалсан зохицуулалтыг бий болгох
4. Санхүү, шийдвэр гаргах үйл явц дах ил тод байдлыг хангах замаар хамтач байдлыг бэхжүүлэх, бие үнэлэгчдийг хянах, гишүүнчлэлийн өсөлтийг дэмжиж, манлайлал болон үр чадварыг дээшлүүлэх
5. Бодлого тодорхойлж боломж бүхий ээлтэй орчин бүтээх: тус бүлгийн эрхийг засгийн газар, хууль сахиулах байгууллагууд, бусад бодлого тодорхойлогчдод сурталчлах
6. Хүний эрхийн төлөө тэмцэгч бусад хөдөлгөөнүүдтэй эв санааны нэгдмэл байдлаар ажиллах замаар тус хөдөлгөөнийг тогтвортой байлгах
7. Явцыг хянах

Үзүүлэлтүүд нь хөтөлбөр зорилгодоо хэрхэн хүрч байгаа талаар бидэнд өгүүлж буй мэдээлэл болон баримтууд юм.

Биеэ үнэлэгчдийн бүлгийн чадавхийн зарим үзүүлэлтүүд:

- Бүх түвшний бодлого, хөтөлбөрт хамруулсан байдал
- Биеэ үнэлэгч удирдлагатай бүлгүүдэд хуваарилсан санхүүжилтийн хэмжээ
- Биеэ үнэлэгч удирдлагатай байгууллагуудын бүх түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- Тус бүлгийн эрхийн чиглэлээр мэргэшсэн нийгмийн үйлчилгээний ажилтнууд, цагдаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн тоо
- Үйлчилгээний загвар, түүнийг түгээх ажил дах Биеэ үнэлэгчдийн оролцооны түвшин
- Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид, цагдаа, нийгмийн үйлчилгээний төлөөлөгчдийн туршлагад ялгаварлан гадуурхалтын хандлага болон түвшинд гарсан өөрчлөлтүүд
- Нийгмийн амьдралд идэвхитэй оролцож буй оролцооны хэмжээ
- Биеэ үнэлэгчдийн нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх түвшин
- Шинээр нэмэгдсэн биеэ үнэлэгчдийн бүлгүүд, түр хамгаалах байрны тоо
- Биеэ үнэлэгчдийн эрхийг дэмжиж сурталчилсан хурал, цуглаан, жагсаалын тоо

БИЕЭ ҮНЭЛЭГЧДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ НЬ

Биеэ үнэлэгчид гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл болон хүний эрхийн бусад зөрчилтэй их тулгардаг. Мөн биеийн, сэтгэл зүйн, бэлгийн гэх мэт олон хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг.

Хүчирхийллийг ажлын байранд, хамтран амьдрагч, найз нөхөд, гэр бүл, олон нийтийн газар, зохион байгуулалттай бүлэг хүмүүс (хуйвалдааны бүлэг, шашны хэт даврагсад, аврах анги) зэрэг олон талаас үзүүлж болно (цагдаа, цэрэг, хорих ангийн харуулууд, хил хамгаалагчид).

Биеэ үнэлэлтийг хуулиар хориглох, эсхүл трансжендер хүмүүс, эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийг ялгаварлан гадуурхах зохицуулалт, бодлого нь хүчирхийлэлд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг байна.

Биеэ үнэлэлтийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн зарчмууд болон түүний үнэ цэнэ:

Гол санаа, үнэ цэнэ

- Биеэ үнэлэгчийн эрхтэй холбоотой хууль зүйн хамгаалалтыг бүрэн дэмжих
- Аврах, нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаанаас татгалзах
- Жендерийн тэгш эрхийг сурталчлах
- Биеэ үнэлэгчдийг амьдралын хэв маягаа сонгох эрхийн талаар мэдээллэх, түүнийг нь хүндэтгэх

Хөтөлбөрийн зарчмууд

- Тухайн газрын биеэ үнэлэгчдэд тохиолддог хүчирхийлэлийн хэлбэр, хэв маягын талаар мэдээлэл цуглуулах
- Асуудлыг тодорхойлж, шийдэл хайхад өөрсдийг нь татан оролцуулах
- Олон нийтэд хандсан эрүүл мэндийн болон хууль зүйн үйлчилгээн цогц хөтөлбөрүүдийг боловсруулах
- Хүчирхийлэл болон ХДХВ-ийн хоорондын холбоо хамаарлыг ойлгуулах болон шийдвэрлэх талаар хөтөлбөрийн ажилтнуудыг чадавхжуулах
- Хор хөнөөлөөс сэргийлсэн байх бололцоог хангах
- Үнэлгээ хийх

Биеэ үнэлэгчдийн хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ болон стратегиуд:

1. Биеэ үнэлэгчдийг чадавхжуулах, эрх мэдэлтэй болгох
2. Биеэ үнэлэгчдийн чадавхийг нэмэгдүүлэх
3. Бодлогын болон эрх зүйн шинэчлэлийн талаар ухуулга, сурталчилгаа хийх
4. Цагдаагийн хариуцлагыг дээшлүүлэх
5. Биеэ үнэлэгчдийн аюулгүй байдал, нүүцлалыг нэмэгдүүлэх
6. Хүчирхийлэлд өртсөн биеэ үнэлэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх

Хөтөлбөр хэрэгжиж эхэлмэгц хяналт үнэлгээг хийх нь чухал бөгөөд заавал шаардлагатай юм.

Учир нь:

- Хүчирхийллийн тоо баримт нь зохистой стратегийг төлөвлөж, зураглал гаргахад чухал ач холбогдолтой.
- Үйл ажиллагаа нь дарангуйлал (хүчтэй хариу үйлдэл) гэх мэт хор хөнөөл бүхий үр дагаварт хүргэж болзошгүй. Хөтөлбөрийн хувьд энэ төрлийн үр дагаврыг тооцоолж, сэргийлэх ёстой.
- Хүчирхийллийн тухай баримтууд нь биеэ үнэлэгчдийн эрхийг хамгаалах хуулийн шинэчлэлд тэднийг өмгөөлөх хүчтэй зэвсэг болно.

Энэхүү хөтөлбөрийг өргөжүүлэхийн өмнө түүнийг үнэлэх шаардлагатай.

Олон улсад биеэ үнэлэгчдэд тохиолддог хүчирхийллийн тодорхой шалгуур үзүүлэлтүүд байдаггүй бөгөөд үйл ажиллагааны үр дүнг үнэлэх хүлээн зөвшөөрөгдсөн стандарт байдаггүй.

Шалгуур үзүүлэлтүүд нь зөвхөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх стратегиудыг үнэлдэг байсан.

Тиймээс энэ тохиолдолд судалгааны үр дүнг цуглуулахын зэрэгцээ чанарын судалгааг хийх хэрэгтэй болно.

ОЛОН НИЙТИЙН МАНЛАЙЛАЛ БҮХИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Олон нийтийн манлайлал бүхий үйлчилгээ гэдэг нь ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хүргэх, хянах ажилд биеэ үнэлэгчид тэргүүлж буй үйлчилгээ юм. Энэ нь биеэ үнэлэгчид өөрсдийн эрхээ эдэлж, ХДХВ-ийн халдвараас сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Биеэ үнэлэгчдийн удирдлага бүхий үйлчилгээ нь биеэ үнэлэгч бус хүмүүс ажилладаг ТББ-аас эхлэлтэй. Биеэ үнэлэгчдийн идэвх санаачлагыг нэмэгдүүлж тэднийг хурдан элсүүлэх, сургалтанд хамруулж, хяналт тавих боломж олгож хариуцлагажуулах хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна.

Биеэ үнэлэгчдийн удирдлага бүхий үйлчилгээний гурван элемент:

- Биеэ үнэлэгчдэд хүрч ажиллах
- Түр хамгаалах байр (үргэлж хүлээж авахад бэлэн байдаг төвүүд)
- Биеэ үнэлэгчдийн холбоо болон зөвлөх бүлгүүд

Биеэ үнэлэгчдийн удирдлага бүхий үйлчилгээг хүргэх

Биеэ үнэлэгчдийн удирдлага бүхий үйлчилгээг хүргэх нь тус хөтөлбөрийн хүрээн дэх ХДХВ-ийн урьдчилан сэргийлэлт, тусламж үйлчилгээ, эмчилгээг биеэ үнэлэгчидтэй холбох үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагаа нь биеэ үнэлэгчдийг өөрсдийн бүлэгт бусадтайгаа хамтран асуудлаа шийдвэрлэх боломж олгодог бөгөөд халдвараас урьдчилан сэргийлэх үйлчилгээг боломжит хэмжээгээр хүртээмжтэй байлгах юм.

Биеэ үнэлэгчдэд хүрч очих ажилтнууд биеэ үнэлэгчидтэй харилцан ойлголцол бий болгож,

тэдний хэрэгцээг хувь хүнийх нь хувьд ойлгож үйлчилгээ үзүүлэх.

Биеэ үнэлэгчдэд хүрч ажиллах үйл ажиллагааны стратеги

- Хүрч ажиллах стратеги боловсруулж, зураглал гаргах
- Хүрч очих ажилчдыг элсүүлэх, сургах
- Биеэ үнэлэгчдэд хүрч ажиллах ажлыг удирдан зохион байгуулах
- Ажилчдын манлайлах боломжийг хөхүүлэн дэмжих

Хүрч ажиллах хэсгийн зураглалыг бүлгийн хэрэгцээ, аюулгүй байдлыг үндэслэн гаргах нь чухал. Мөн мэдээллийн зураглал нь нууцлалтай байх шаардлагатай. Хууль сахиулах байгууллагууд болон бусад эрх баригчид энэхүү мэдээллийг ашиглан биеэ үнэлэгчдэд шууд хохирол учруулж эрхэд нь халдах эрсдэлтэй тул мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангаж ажиллах хэрэгтэй.

Түүнчлэн ажилчдад урамшууллын тухайд жишээ татвал, эрүүл мэндийн тусламж үзүүлэх байгууллага, аюулгүйн төвүүдэд /түр хамгаалах байр/ авчирсан хүний тоогоор төлбөр төлөх нь эрэлтийг гажуудуулж, дарамт шахалтанд хүргэх магадлалтай. Тиймээс утасны нэгж, мөнгөн бус бэлэг, манлайллын боломжууд зэрэг илүү үр дүнтэй урамшууллын аргуудыг ашиглах нь зүйтэй. Дотоодын болон олон улсын сургалт, уулзалтуудад хамрагдах боломж санал болгох нь ажилчдыг таниулах бас нэг боломж билээ.

Аюулгүй орон зай

Аюулгүй орчин (түр хамгаалах байр) гэдэг нь энэхүү хөтөлбөрийн бүлэгт хамаарах гишүүдэд амрах, тайвшрах, мэдээлэл авах, бие биетэйгээ харилцах, тус хөтөлбөртэй харилцах боломж бүхий байр орон юм.

Аюулгүйн төв байгуулахад анхаарах зүйлс:

- **Зөвлөлдөөн болон зураглал гаргах:** байршил сонгох, ямар үйлчилгээ үзүүлэх, ажилчид, ажиллах цагийн хуваарь зэргийг шийдэх. Энэ тохиолдолд түс төв биеэ үнэлэгчдэд шаардлагатай бүхий л нөхцөлд ажиллаж байх
- **Байршил:** бүлгийг хамруулах боломжит хүртээмж, олон нийтийн харагдах байдал, тухайн бүсийн иргэдийн биеэ үнэлэгчдэд хандах хандлагыг харгалзан үзэх
- **Түрээсийн гэрээ:** байршлыг тогтмол хадгалах нь үйлчилгээг тасалдуулахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой. Түрээслүүлэгчтэй байгуулсан түрээсийн гэрээнд гэрээний хугацаа, ашиглалтын цаг, зориулалтыг тодорхой заасан байх
- **Дэд бүтэц, аюулгүй байдал:** хамгийн багадаа 2 өрөөтэй байх. Нэг нь уулзалт зөвлөгөөний өрөө, нөгөө нь олон нийтэд зориулагдсан байх. Галын болон бусад онцгой байдлын үед хэрэглэх тоног төхөөрөмжтэй байх
- **Орчин:** олон нийтийн хэрэгцээ шаардлагад тохирсон үйл ажиллагаатай байх. Тохь тухтай ор, матрасс болон уулзалтын ширээ сандал зэргийг

бэлтгэх. Ханыг чимэглэж зурж болно.

Аюулгүй байрны үйл ажиллагаанд анхаарах зүйлс:


- **Удирдлага:** биеэ үнэлэгчид байртай холбоотой зохицуулалт хийх, шийдвэр гаргахад тэргүүлэх үүрэгтэй.
- **Үйлчилгээний сурталчилгаа:** интернет хуудас, мессеж болон биеэ үнэлэгчдийн бүлгээр дамжуулан сурталчлах
- **Дүрэм:** тухайн орон байрыг ашиглаж буй бүлэгт зориулсан дүрэм гаргах
- **Хөршийн харилцаа:** байрны эргэн тойрныг цэвэрлэх гэх мэтээр хөрш, эргэн тойрныхонтой харилцах харилцааг зохицуулах.
- **Хуваарь:** үйл ажиллагааг оргил бус цагаар (оройн 10 цагаас өглөөний 7 цаг) явуулах. Ингэснээр бүлэг айж ичилгүй нэвтрэх боломжтой.
- **Хөтөлбөрийн хэрэглээ:** бусад байгууллагууд байрыг зорилгоос гадуур ашиглах хүсэлт гаргавал аль болох хүсэлтээс татгалзах, хөтөлбөрөөс гадуур үйл ажиллагаа хамгийн бага байхад анхаарах
- **Тогтвортой байдал:** биеэ үнэлэгчдийн бүлгээр удирдуулж байх үед санхүүгийн хувьд тогтвортой байх боломжтой. Мөн байрыг хязгаарлагдмал хүрээнд түрээслэх замаар эсхүл биеэ үнэлэгчдийн бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулан орлого бий болгож болно. Жишээ нь: катеринг үйлчилгээ гэх мэт.

Аюулгүй байрны хэрэгжүүлэх боломжтой бусад үйл ажиллагаанууд:

- Хэл бичгийн, тоо, мэдээллийн технологийн, хоол тэжээлийн болон бүжгийн ангиуд
- Гоо сайхны зөвлөгөө (өөр өөр бүлгүүдэд зориулсан)
- Цаг авах шаардлагагүй эрүүл мэндийн ерөнхий үзлэг

- Шүршүүр болон угаалга хийх байгууламжууд
- Бүлгийн гишүүдийн эд хогшлыг хадгалах шүүгээнүүд
- Унтах, амрах хэсэг
- Компьютер, интернет
- Биеэ үнэлэгчдийн хүүхдүүдийг асрах үйлчилгээ

1-Шалан дээр матгасс, дэр байрлуулах



Биеэ үнэлэгчдийн хороо болон зөвлөх бүлгүүд

Энэхүү хороо нь биеэ үнэлэгчдэд хөтөлбөрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, үнэлгээ өгөхөд бүлгийг хамруулах гол хэрэгсэл юм.

Биеэ үнэлэгчдийн хороо

- Биеэ үнэлэгчдийг хөтөлбөрийн чухал асуудлууд, түлгарч буй асуудлууд тэдгээрийг шийдэх арга замыг илэрхийлэх байнгын боломж олгосон
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нөөцийн хуваарилалт, аюулгүй байрны үйл ажиллагаа, бүтцийн саад тотгорыг шийдвэрлэх санааг хянах
- Сар бүр хэлэлцэх, тайлагнах
- Бүлгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хуваалцах
- Хяналтын мэдээллийг хуваалцах

Тус хорооны гишүүд тогтмол сонгогддог байх.

Үйлчилгээний чанарыг сайжруулахад бүлгийн хэрэгжүүлэх арга барил

- Үйлчлүүлэгчдийн мэдээллийн нууцлалын эрхтэй холбоотойгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтнуудтай нууц хадгалах хэлэлцээр хийх
- Биеэ үнэлэгчдэд найдвартай, итгэж болохуйц үйлчилгээний тухай мэдээллийг хүргэх аргуудыг тодорхойлох
- Биеэ үнэлэгчдэд өөрсдийнх нь эрхийн талаар боловсрол олгох
- Хорооны гишүүд эрүүл мэндийн албан тушаалтантай холбоо тогтоож хорооны гишүүдийг танилцуулах

Бүх хөтөлбөрийг дараах үзүүлэлтээр хянаж үнэлнэ:

- Биеэ үнэлэгчдэд хүрч ажилладаг ажилтнуудын тоо
- Өөрийн биеэр ажилтнуудад хандаж үүлзсэн биеэ үнэлэгчдийн тоо сараар
- Биеэ үнэлэгч нарт сар бүр тараасан бэлгэвчний тоо
- ХДХВ болон БЗДХ-ын шинжилгээ зөвлөгөөнд хамрагдсан биеэ үнэлэгчдийн тоо
- ХДХВ болон БЗДХ-ын тогтмол шинжилгээ хийлгэдэг биеэ үнэлэгчдийн тоо
- Эрүүл мэндийн тусламж авсан ХДХВ-ийн халдвар тээгч биеэ үнэлэгчдийн тоо

БЭЛГЭВЧ БОЛОН ЧИЙГШҮҮЛЭГЧИЙН ХӨТӨЛБӨР

Бэлгэвч, чийгшүүлэгчийг үр дүнтэй хангах, түгээх, сурталчлах нь биеэ үнэлэгчдийн ХДХВ-ийн халдвараас сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Мөн халдвар тараахаас сэргийлэх хамгийн үр дүнтэй хэрэгсэл юм.

Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлнэ гэдэг нь биеэ үнэлэгчдийг бэлгэвч болон чийгшүүлэгчээр тогтмол, түүштай хангана гэсэн үг юм. Хөтөлбөр нь бэлгэвчний хэрэглээн дэх нийгмийн болон хууль зүйн саад бэрхшээлийг тодорхойлох, шийдэх юм.

Үр дүнтэй бэлгэвчний хөтөлбөр гэдэг нь:

- Хүртээмжтэй хангамжыг бий болгох
- Олон түвшний сурталчилгаа
- Боломжит орчныг бүрдүүлэх юм.

Үр дүнтэй нийлүүлэлт гэдэг нь:

- Урьдчилан таамаглал
- Худалдан авалт
- Чанарын баталгаа
- Агуулах, хадгалалт
- Түгээлт
- Тээвэр юм.

Олон түвшний сурталчилгаанд биеэ үнэлэгчдийн бүлэгт бэлгэвч сурталчлах болон нийгэмд өргөн хүрээнд бэлгэвчийг түгээн дэлгэрүүлэх зэрэг багтана.

Бэлгэвчний хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжит орчныг бүрдүүлэхэд:

- бодлого, хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд дэмжих
- энэхүү бодлогын хүрээг зөв хэрэгжүүлэх
- холбоо бүхий байгууллагууд, хувь хүмүүсийн дэмжлэгтэйгээр болон биеэ үнэлэгчдээр дамжуулан нийгэмд хүргэх юм.

Ямар ч тохиолдолд бэлгэвчний сурталчилгаа албадлагын бус байна. Түүнчлэн 100 хувь бэлгэвчний хэрэглээний бодлого нь хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж, хүний эрхийг зөрчихөөс зайлсхийх шаардлагатай.

Бэлгэвчний хөтөлбөрийн талаарх бусад анхаарах зүйлс:

- Эрэгтэй болон трансжендер биеэ үнэлэгчдийн хувьд: эмэгтэй, эрэгтэй, трансжендер биеэ үнэлэгчдийн үзүүлж буй бэлгийн үйлчилгээ нь өөр байдаг учир энэхүү хөтөлбөр тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж эдгээр бүлэг хүмүүстэй хамтран ажиллах нь чухал байна.
- Бэлгэвчний тохиролцоо хийх стратегиуд
- Биеэ үнэлэгчдийн үйлчлүүлэгчдэд зориулсан бэлгэвчний хөтөлбөр
- Бэлгэвчний нийгмийн маркетингийн хөтөлбөрүүд: хямд үнэтэй, бэлгэвч болон чийгшүүлэгчийг хувь хүмүүст худалдах. Энэ нь тус хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахаас гадна бэлгэвч, чийгшүүлэгчийн өргөн сонголтыг хэрэглэгчдэд санал болгоно.

Бэлгэвчний хөтөлбөр нь засгийн газрын байгууллагууд болон ТББ-уудын олон түвшинд байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд явагдана. Түүнчлэн хөтөлбөрт тогтмол хяналт, үнэлгээ шаардлагатай.

ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН ДЭМЖЛЭГ

Биеэ үнэлэгчдэд зориулсан хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, боломжийн үнэтэй эмнэлгийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь эмнэлгийн орчинд тулгардаг гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй өвөрмөц сорилтуудыг бий болгодог. Гэсэн ч эмнэлгийн үйлчилгээ ямар байх ёстойг тооцоолсон загвар түүний хэрэгжилт болон хяналтанд биеэ үнэлэгчид өөрсдөө оролцож чадвал энэхүү үйлчилгээгээр дамжуулан биеэ үнэлэгчдийн бүлгийг (олон нийт) чадавхжуулж, эрх мэдэлтэй болгох боломжтой юм.

Биеэ үнэлэгчдэд олгох үйлчилгээг тооцоолж тэдэнд хүргэхэд дараах голлох зарчмууд үйлчилнэ. Үүнд:

1. Сайн дурын, мэдээлэл бүхий зөвшөөрөл: биеэ үнэлэгчид эмчилгээ хийлгэх болон эмчилгээ үйлчилгээ авахаас татгалзах хууль ёсны эрхтэй. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч этгээд нь бүх журмыг тайлбарлаж, биеэ үнэлэгчийн шинжилгээ хийлгэх, эмчилгээ хийлгэхээс татгалзсан татгалзлыг хүндэтгэх үүрэгтэй байна.
2. Нууцлал: эмчийн бичиг, шинжилгээний бичиг гэх мэт үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг чандлан хадгална. Биеэ үнэлэгчид албан ёсны нэрнээсээ өөр мэдээллийг ашиглах эрхтэй (албан бичиг баримт эсхүл биометрийн өгөгдөл шаардагдахгүй). Үйлчилгээний дугаараар тасралтгүй үйлчлүүлэх эрхтэй байна.
3. Боломжит үйлчилгээ: эмнэлгийн үйлчилгээ

нь үр дүнтэй, чанарын өндөр түвшинд биеэ үнэлэгчийн хэрэгцээ, цагт тохирсон байна. Мөн үйлчилгээ нь олон улсын стандартын дагуу хамгийн сайн туршлага, зааварт тулгуурласан байна.

4. Хүртээмжтэй байдал: биеэ үнэлэгчдэд эмнэлгийн үйлчилгээ цаг хугацааны хувьд болон газар зүйн хувьд хүртээмжтэй байх шаардлагатай. Мөн боломжтой бол нэг дор олон шаардлагатай үйлчилгээг зэрэг авах боломжоор хангасан байвал зохино.
5. Хүлээн зөвшөөрөгдсөн: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн хувьд ухаалаг, үйлчлүүлэгчээ шүүх хандлагагүй, гутаан доромжилсон бус байх ёстойгоос гадна биеэ үнэлэгчийн эрүүл мэндийн онцгой хэрэгцээг ойлгож, шийдэх боломжтой байхаар бэлтгэгдсэн байна.
6. Боломжийн үнэтэй: тээврийн зардал болон үйлчилгээ үзүүлэгчид очиж орлого олох боломжоо алдсан зэргийг харгалзан үзэж эмнэлгийн үйлчилгээ нь биеэ үнэлэгчдэд үнэгүй эсхүл үйлчлүүлэгч төлж чадах хэмжээний боломжит үнэтэй байх

Сайн дурын ХДХВ-ийн зөвлөгөө, шинжилгээ

Сайн дурын зөвлөгөө шинжилгээ нь ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх, эмчлэх цогц хөтөлбөрийн нэг хэсэг юм. Биеэ үнэлэгчид, тэдний хамтран амвдрагчид, гэр

бүлийнхэн нь цаг хугацаа байршлын тохиромжтой газруудад ХДХВ-ийн шинжилгээнд байнга хамрагдаж байх шаардлагатай.

Бэлтгэх нь:

- **Мэдлэг болон эрэлтийг бий болгох:** Биеэ үнэлэгчид ХДХВ-ийн халдвартай эсэхээ мэдэж авахын давуу талууд болон халдвар авсан тохиолдолд эмчилгээ хийлгэх боломжтой эсэхээ мэддэг болох нь чухал.
- **Үндэсний болон олон улсын стандартын дагуу ажилладаг сургалт зохион байгуулагчид, биеэ үнэлэгчдэд хүрч ажиллах ажилтнууд**
- **Байршил болон цаг хугацаа:** биеэ үнэлэгчидтэй зөвлөлдөж тэдний хэрэгцээ шаардлагыг харгалзаж үзэх
- **Зайлшгүй хэрэгцээтэй барааг нийлүүлэх**

ХДХВ-ийн шинжилгээ, зөвлөгөө бүхий үйлчилгээ:

- Шинжилгээний өмнөх мэдээлэл: энэ үед ХДХВ-ийн талаарх ерөнхий мэдээлэл болон шинжилгээний тухай байна. Шинжилгээ нь бүх үед сайн дурын үндсэн дээр явагдана.
- Шинжилгээний дараах зөвлөгөө: зөвлөгөө нь шинжилгээ дууссаны дараа явагдана. Хэрэв үйлчлүүлэгч нь ХДХВ-ийн халдвартай бол үрт хугацааны эмчилгээ зөвлөгөө шаардлагатай

бөгөөд халдварыг тараахгүй байх талаар тухайн цаг мөчид хэлж зөвлөх зайлшгүй шаардлагатай. Шинжилгээнд хамрагдсан бүх үйлчлүүлэгчдэд бэлгэвч, чийгшүүлэгч хэрэглэх, халдварын эрсдэл бууруулах аргуудыг зөвлөнө.

- Дахин шинжилгээнд хамрагдах: ХДХВ-ийн халдваргүй биеэ үнэлэгчдэд дахин шинжилгээ өгөхийг санал болгоно.
- Хамтрагч болон гэр бүлийнхэн шинжилгээнд хамрагдах: ХДХВ-ийн халдвар тээж буй биеэ үнэлэгч хэрэв хүсвэл өөрийн гэр бүлийн гишүүнд статусаа хэлж болно. Мөн тэдний гэр бүлийн гишүүд, хамтрагчид сайн дураар шинжилгээнд хамрагдах боломжтой.

Дараагийн шат:

- Урьдчилан сэргийлэх үйлчилгээ: бэлгэвч болон чийгшүүлэгч хэрэглэж халдвараас урьдчилан сэргийлэх талаар нийтэд хүргэх
- Халамж болон тусламжын үйлчилгээ: ХДХВ-ийн халдвартай ямар ч этгээд халамж болон эмнэлгийн тусламж саадгүй хүртэх

Хүрч очих ажилтнууд сайн дурын зөвлөгөө шинжилгээнд хамрагдах үйлчилгээг биеэ үнэлэгч олон нийтэд санал болгоно.

Ретровирусын эсрэг эмчилгээ (РВЭЭ)

ХДХВ-ийн халдвар тээгч энгийн иргэдээс илүүтэйгээр биеэ үнэлэгчид тусламж үйлчилгээ авахдаа гутаандоромжилсонхандлага,ялгаварлан гадуурхалт, уян хатан бус байдал, тохь тухгүй үйлчилгээ зэрэг сорилтуудтай нүүр тулгардаг.

Уян хатан цаг, биеэ үнэлэх цэгүүдэд ойрхон байршилтэй үйлчилгээ үзүүлэх цэгүүд, биеэ үнэлэгчдийг цаг харгалзахгүй хүлээн авах байр, яаралтай тусламжын эм, биеэ үнэлэгчдэд хүндэтгэлтэй хандах эмнэлгийн ажилтнуудын хандлага зэрэг нь ретровирусын эсрэг эмчилгээг үр дүнтэй байхад чухал үр нөлөөтэй юм.

ДЭМБ-аас хамгийн сүүлд гаргасан РВЭЭ-ний удирдамжыг ХДХВ-ийн халдвар тээж буй иргэдэд, ялангуяа биеэ үнэлэгчдэд зориулан хэрэглэх нь зүйтэй.

Сүрьеэ

Биеэ үнэлэгчдийн сүрьеэгийн оношилгоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ нь олон улсын болон үндэсний хамгийн орчин үеийн удирдамжын дагуу явагдах ёстой. ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн хувьд сүрьеэ өвчнөөр өвчлөх магадлал их байдаг. Тийм учраас сүрьеэ болон ХДХВ-ийн хавсарсан эмчилгээг хийлгэх боломжтой байх нь чухал юм.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгч биеэ үнэлэгчдэд зориулсан нэмэлт үйлчилгээ

Дэлхийн зарим улсад нэг дор мансууруулах бодис хэрэглэдэг биеэ үнэлэгч байх үлэмж давхцал бий болсон байна. Мансууруулах бодис хэрэглэгч биеэ үнэлэгчдэд ялангуяа ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эмчилгээ хийлгэх, тусламж үйлчилгээ авах шаардлагатай. Мансууруулах бодисын сайн дурын зөвлөгөө шинжилгээ, эмнэлэгийн тусламж авах боломжыг эдгээр иргэдэд олгох нь чухал юм.

Түүнчлэн, опиоид орлуулах эмчилгээ, зүү, тариурын хөтөлбөрүүд нь ХДХВ-ийн халдварыг бууруулахад үр дүнтэй байдаг.

БЗДХ-ийн үйлчилгээ

БЗДХ-ыг илрүүлэх, эмчлэх нь халдвар тархахаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. БЗДХ-ын үйлчилгээ нь нэн тэргүүний асуудал бөгөөд хүний эрхийг дээдэлсэн, нууцлалтай, сайн дурын үндсэн дээр байх ёстой.

Өртгийн хувьд хэмнэлттэй, БЗДХ-ын тархалтыг цаг хугацааны явцад бууруулах боломжтой хамгийн гол арга бол иргэдээс шинж тэмдэггүй халдварын тогтмол шинжилгээ болон лабораторын шинжилгээ авах юм. Лабораторын оношлогоонд мэргэжлийн боловсон хүчин ажиллуулж чанарын баталгааны тогтолцоог бий болгох нь энэхүү үйлчилгээнд чухал.

Лабораторын шинжилгээ байхгүй тохиолдолд ч биеэ үнэлэгчдэд БЗДХ-ийн үзлэг хийж байх шаардлагатай. Байнгын үзлэгээр тэдэнд урьдчилан

сэргийлэхийг үхүүлж ойлгуулах боломж гарах бөгөөд үзлэгт биед илэрч буй шинж тэмдгийн талаар ярилцаж, халдварын шинж тэмдэг илэрч буйг шалгах боломжтой.

Шинж тэмдэг илэрч байвал даруй үр дүнтэй арга хэмжээ авна. Энэ тохиолдолд халдварыг илрүүлэх шинжилгээ хийх боломжгүй бол, ДЭМБ-аас халдварын шинж тэмдгийн эмчилгээ хийхийг санал болгодог.

БЗДХ-ийн үйлчилгээ нь дараах дөрвөн элементтэй байна. Үүнд:

- 1. БЗДХ-ийн үйлчилгээг загварчлах нь:** одоогийн явуулж буй үйлчилгээг үргэлжлүүлэх, биеэ үнэлэгчдэд зориулсан БЗДХ-ын үйлчилгээний багц болон бусад үйлчилгээг тодорхойлох, зохион байгуулах
- 2. БЗДХ-ийн үйлчилгээг хэрэгжүүлж удирдах нь:** БЗДХ-ийн үйлчилгээг бий болгож тусламж үйлчилгээг эрэлхийлэх зан үйлийг хэвшүүлэх. Мөн бүтцийн хувьд бэрхшээл болж буй асуудлуудыг хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байдлааг шийдвэрлэх, эмнэлгийн үйл ажиллагаанд биеэ үнэлэгчид болон тэдэнд хүрч очих ажилтнуудыг татан оролцуулах, хамгийн боломжит өндөр чанар бүхий үйлчилгээг түгээх болон үйлчилгээг нэгтгэж холбох
- 3. Урьдчилан таамаглах тогтмол эмчилгээ:** эмчилгээг бэлгийн эрүүл мэндийн цогц үйлчилгээний нэг хэсэг болгож БЗДХ-ийн

тархалт өндөр байгаа тохиолдолд (15 хувиас их) богино хугацааны арга хэлбэрээр хэрэглэнэ. Энэхүү эмчилгээг аажмаар багасгах ёстой учир нь биеэ үнэлэгчдэд эмчилгээнээс үүдэлтэй хор уршиг илэрч байсан байна. Биеэ үнэлэгчдэд эмчилгээний талаар бүрэн танилцуулсны дараа сайн дурын үндсэн дээр эмчилгээг хийж эхлэнэ.

- 4. Вируст гепатит:** Нярайн үеийн вакцинжуулалтанд бүрэн хамрагдаагүй тохиолдолд биеэ үнэлэгчдийг гепатит В вирусын вакцинжуулалтанд хамруулах шаардлагатай.

Биеэ үнэлэгчдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээт асуудлыг шийдвэрлэх

Аль ч хүйсийн биеэ үнэлэгчид бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээ зайлшгүй байдаг. Энэ тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээнд:

- Гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах аргууд . Жишээ нь- яаралтай туслаж зэрэг
- Аюулгүй жирэмслэлт
- Үр хөндөлт болон үр хөндөлтийн дараах арчилгаа, сувилгаа
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн иргэнд зориулсан эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Трансгендер биеэ үнэлэгчдэд зориулж даавар хэрэглэх болон хүйсийн шилжилтийн талаар зөвлөгөө өгөх

Сэтгэцийн эрүүл мэнд

Сэтгэцийн хувьд эрүүл байх нь хүн бүрийн аз жаргалтай амьдрах хамгийн чухал нөлөө бүхий зүйл билээ. Ядуурал, гэмт хэрэг, ялгаварлан гадуурхалтаас үүдэн биеэ үнэлэгчид сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд өртөх боломжтой байдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас болж ХДХВ-ийн эмчилгээ, үйлчилгээнд тогтмол хамрагдаж чадахгүй байх асуудал үүсэх боломжтой бөгөөд энэхүү хөтөлбөр сэтгэцийн эрүүл мэндийн хяналт тавин, учирч болох бэрхшээлийг шийдвэрлэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА

Энэхүү БЗДХ, ХДХВ-ийн эсрэг биеэ үнэлэгчдэд зориулсан хөтөлбөрүүд нь ижил төстэй олон асуудлыг шийдвэрлэсэн нэг цогц юм.

Төрийн болон хувийн хэвшлээс гадуур үйлчилгээг бий болгоход удирдлагын бүтэц, үйл ажиллагааг төлөвлөх нь чухал. Санхүүжилтийн хувьд хэд хэдэн эх үүсвэртэй байх боломжтой агаад тус бүр тайлагнах янз бүрийн шаардлагуудтай байна.

- Хамрах хүрээ: Хамрах хүрээ өргөн байх нь хүн амын түвшинд үзүүлэх нөлөөллийг бий болгоход чухал ач холбогдолтой
- Хөдөлгөөнт байдал болон шилжилт хөдөлгөөн: Биеэ үнэлэгчид хот, улс, хил дамнан шилжих боломжтой учраас тэдэнд хүрч очиж ажиллах болон нөөц бололцоог харгалзан уян хатан хандаж тухайн оршин байгаа газрын хэлээр ярьдаггүй биеэ үнэлэгчдэд үйлчлэх.
- Биеэ үнэлэгчдийн манлайлал: хөтөлбөр нь биеэ үнэлэгчдэд удирдан зохицуулах, хянах боломжыг олгосон байр суурийг санал болгосон байх
- Бүтцийн хязгаарлалтыг шийдвэрлэх: ХДХВ-ийн арга хэмжээ нь биеэ үнэлэгчдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж буй томоохон хүчин зүйлсийг шийдвэрлэнэ. Жишээ нь: гэмт хэрэгт өртөх магадлал, ялгаварлан гадуурхалт, ядуурал.
- Мэдээллийн нууцлалыг чанд хадгалах: хөтөлбөрийн дотоод үйл ажиллагаанд биеэ үнэлэлтийн цэг болон тэдний талаарх мэдээлэл чухал ач холбогдолтой. Гэсэн ч

тэдэнд хор хөнөөл учирч болзошгүй хүчин зүйлсээс хамгаалах үүднээс тэдний мэдээллийг хамгаалах шаардлагатай.

- Уян хатан, тасралтгүй суралцах: биеэ үнэлэлтийн орчин хувьсан өөрчлөгдөж байгаа учир шаардлагатай тохиолдолд тохирсон өөрчлөлт, шинэчлэл хийж байх

Хөтөлбөрийн удирдлага нь тус хөтөлбөрийг тогтвортой байдлаар өөрчлөн шинэчлэж байхаар, өргөн цар хүрээгээр ажиллахад ач холбогдолтой. Түүнчлэн удирдлагын тогтолцоотой байх нь тус хөтөлбөр зорилго, зорилттойг харуулж байгаагаас гадна чанарын стандартыг хангаж, шат дараатай үйл явцыг бий болгосныг илтгэнэ. Үүн дээр хяналтын болон тайлагнах системийг хэрэгжүүлж үр өгөөжтэй хөтөлбөрийн удирдлагыг бий болгох юм. Энэ нь санхүүжилт болон хамтарч ажиллах холбоог тогтвортой байлгахад ач холбогдолтой.